



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-9

- 1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 4-7
- 2. Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсох* 7-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 11-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Доржханд, Б.Пүрэвдорж;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Х.Нямбаатар;
Тасалсан: Г.Ганболд, Д.Сарангэрэл.*

Нэг.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, мөн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Лхамжав, Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах референт Ж.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Н.Энхболд нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Лхамжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 18 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 10 сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хурал дээр 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Энэ төслийг Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн 2023 оны 10 сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг нь Байнгын хороогоороо шийднэ.

Хоёрдугаарт, Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл, цаг үеийн үйл явц, бэлтгэл ажлууд ямар байна гэдэг талаар.

Мөн хууль гарсныг сурталчилсантай холбоотой мэдээлэл Сонгуулийн ерөнхий хорооноос хийх юм.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэг.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт орлуулах тухай хуулийн төсөл

*/Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нарын 3 гишүүн
2023.10.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Одоо Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Г.Амартүвшин, Т.Аубакир, Т.Энхтүвшин нарын санаачилсан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулна.

Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байхаар тогтоож, мөн хугацаанд ээлжит сонгууль зохион байгуулагдсан билээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж хуульчилсан нь 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хугацааг тодорхойлжээ.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагын өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх, сонгуулийг нээлттэй, хяналттай зохион байгуулж явуулах удирдлага зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Тухайлбал, сонгуульд оролцож буй нам, эсвэл нэр дэвшигчдээс зарцуулах зардлын хэмжээг бууруулах чиглэлээр сонгуулийн сурталчилгааны хуулиар зөвшөөрсөн арга хэлбэр, түүний тоо хэмжээг 50 хүртэл хувиар бууруулах, зардлын дээд хэмжээг тогтоохдоо

сонгуулийн зардлыг бууруулах чиглэлийг баримтлах.

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, давхардлыг арилгах, нягтлан шалгах, үйл ажиллагааны ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт, мониторинг хийх, төрийн бус байгууллагуудын оролцоог хуульчлах.

Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах, буруу бүртгэгдсэн тохиолдолд гомдол гаргах хэлбэрүүдийг нэмэгдүүлэх, санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын үр дүнг 100 хувь гар аргаар давхар тоож хяналтын тооллого хийх зэрэг сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх чиглэлийн нарийвчилсан зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай юм.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг болон эрх зүйн орчныг сайжруулах талаарх дээрх шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

Уг хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт хуульчилсан дээрх хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн тул хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн

тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт хуульчилсан нэг жилийн хугацаагаар 6 сар болгон өөрчлөх зохицуулалтыг тусгасан байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Г.Амартүвшин гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн оролцож байна. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ оролцож байгаа.

Одоо хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуулт тавих гишүүн байна уу? Байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн алга байна.

Ер нь цагаа олсон зохицуулалтыг нь заавал шинэчлэх ёстой хууль болсон гэдэг нь бараг харагдаж байна даа.

Одоо ингээд санал хураалт явуулна. Бид хэлэлцэх эсэхээр санал хураалт явуулна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд саналаа өгөөрэй.

12 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 58.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ж.Батсуурь гишүүн танилцуулчих уу.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн М.Оюунчимэг гишүүнээр.

Энэ чинь нэг жилийн өмнө гэснийг хуулиа илүү нухацтай, тал талаас нь, олон талаас нь ярилцъя гэдэг үүднээс.

Тэгэхгүй 2 хоногийн дараа батлах гээд байгаа байхгүй юу. Энэ хуулийг чинь. Хуучнаар.

Дараагийн асуудалдаа орё.

Хоёр.Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсох

Хэлэлцэх асуудлын дагуу одоо Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсоно.

Сонгуулийн ерөнхий хороог урья.

Байнгын хорооны хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнарэн, Сонгуулийн ерөнхий

хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, мөн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Лхамжав, Захиргаа,

санхүүгийн хэлтсийн ахлах референт Ж.Оюунгэрэл нар оролцож байна.

П.Дэлгэрнаран даргыг урья. Мэдээллээ танилцуулахыг урьж байна. 3 номерын микрофон өгөөрэй.

П.Дэлгэрнаран: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийгдэж буй ажлын талаар Та бүхэнд мэдээлэл өгье.

Улсын Их Хурлын сонгуулийг хосолсон тогтолцоогоор зохион байгуулах, гадаад улсад байгаа иргэдээс санал авах, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, сонгуулийн зардлыг бууруулах зэрэг чиглэлээр 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Мөн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.

Энэхүү хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нам, улсын нам, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллах, намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байх, бодлогын нам болж хөгжихөд төрөөс шууд болон шууд бус

байдлаар дэмжлэг үзүүлэх зэрэг зарчмын олон өөрчлөлтийг хуульчилсан.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрөөс үзүүлэх шууд болон шууд бус дэмжлэг үзүүлэх, намын дотоод зохион байгуулалтын байгуулалтын бүтэцтэй холбоотой зохион байгуулалтыг 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа дагаж мөрдөхөөр хуульчилсан.

Дээрх хоёр хууль нь үзэл баримтлал, зохицуулалтын хувьд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шинэ тутам хуульчлагдсан тул хуулийн хэрэгжилтийг хангах, бэлтгэлийг бүрэн хангах, сонгогч, иргэд олон нийтэд хууль тогтоомжид оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл, ойлголт өгөх уулзалт, сургалтыг өргөн хэмжээтэй зохион байгуулах, шаардлагатай хүний болон бусад нөөцийг бүрдүүлэх, бэхжүүлэх нь нэн тэргүүнд зохион байгуулах шаардлагатай үйл ажиллагаа юм.

Иймд 2023 онд Сонгуулийн ерөнхий хорооны А40 дүгээр захирамжаар Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж байна.

Уг төлөвлөгөөнд үндсэн 5 чиглэлийн, нийт 27 арга хэмжээ тусгасан болно.

Нэг.Бэлтгэл, зохион байгуулалтын ажлын хүрээнд:

1.Сонгуулийн тэгш өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, сонгогчдод

ойлгомжтой, хүртээмжтэй сонгуулийн сурталчилгааны эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан сурталчилгааны нэгдсэн самбар ашиглахаар хуульчилсан. Нэр дэвшигчийн.

Нэгдсэн самбар нь сумд 2, аймгийн төвд 5, нийслэлийн хороонд 4 хүртэл хэмжээтэй байх бөгөөд уг самбарыг сум, дүүргийн Засаг дарга бэлтгэж байршуулах ажлыг зохион байгуулахаар хуульд тусгагдсан.

Нэгдсэн самбарын зураг төсвийг Барилгын хөгжлийн төвд хүсэлт гаргаж хийлгүүлсэн бөгөөд уг тооцооллыг Сангийн яам, 330 сум, нийслэлийн 9 дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт энэ оны 07 дугаар сарын 05-нд зөвлөмжөөр хүргүүлсэн болно.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэл явахаас өмнө төсвийг хийгээд албан хэрэгцээнд Сангийн яам манай хоёрт хэрэгжиж байгаа.

Ингээд энэ аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт энэ жил тусгагдаж, 2024 онд уг самбарын төсөв, загварууд бэлэн болж ашиглахад бэлэн болох юм.

2. Сонгуулийн тогтолцоо болон Улсын Их Хурлын гишүүдийн тооны өөрчлөлттэй холбоотойгоор сонгуульд нэр дэвшигчийн тоо нэмэгдэнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар нэр дэвшигч 9-өөс 11 төрлийн лавлагааг дэвшигчээр бүртгүүлэхийн тулд бүрдүүлдэг.

Иймд нэр дэвшигчийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, холбогдох

лавлагаа, тодорхойлолтыг цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан цахим системийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хөгжүүлж байна.

Энэхүү систем нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад үүсдэг олон төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимаар авах, бүрдүүлэх боломжтой юм.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн e-mongolia үйлчилгээний төрөлд нэмэгдсэн бөгөөд 2023 оны орон нутгийн нөхөн болон дахин сонгуулиар уг системийг туршиж бэлэн болгосон.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хоёр дахь жилдээ зохион байгуулж байгаа 18-аас 25 насны сонгогчдод сонгуулийн ач холбогдол, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны онцлог, сонгуульд хариуцлагатай оролцох тухай мэдлэг ойлгох, “Хариуцлагатай сонгогч” албан бус үндэсний хөтөлбөрийн агуулгад нэмэлт, өөрчлөлт оруулан сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Үйл ажиллагааны хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт 110 сургагч багш бэлтгэсэн бөгөөд одоогоор 18-аас 25 насны 4400 сонгогчдод дээрх чиглэлээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулаад байна.

4. Улс төрийн намын тухай хуульд зааснаар төрөөс намд үзүүлэх шууд дэмжлэгийг 2024 оны Монгол Улсын Их

Хурлын ээлжит сонгуулийн дүнг үндэслэн тооцож, улмаар хуульд заасан шаардлага хангасан намд 2025 оны 1 дүгээр сараас эхлэн энэхүү шууд дэмжлэгийг үзүүлж эхэлнэ.

Мөн шууд бус дэмжлэг буюу намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд дэмжигчидтэйгээ хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг сонгуулийн бус жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах зохицуулалтын хэрэгжилтийг хангах бэлтгэлийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газрууд үйл ажиллагаандаа, төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж ажиллах талаар бид ажиллаж байна.

5. Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хороо Улсын Дээд шүүхтэй хамтран намын дарга дүрэм, хөрөнгө, түүний өөрчлөлтийг бүртгүүлэх, намыг идэвхгүйд тооцох баримт бичгийг бүрдүүлэх журмыг батална.

Сангийн яамтай хамтран намын санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, хөрөнгө, орлого, зарлагын ангиллыг тодорхойлон тайлагнах журмыг батална.

Үндсэн төлөвлөгөөний дагуу журмын төсөл боловсруулах бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хэсгийг хорооны нарийн бичгийн даргаар ахлуулан ажиллаж байна.

6. Сонгуулийн ерөнхий хороо Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд Бүгд Найрамдах

Солонгос Улсын Үндэсний сонгуулийн комиссоос дээрх чиглэлээр мэдээлэл авах, туршлага судлах уулзалтыг Дэлхийн сонгуулийн байгууллагын холбоо болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2023 оны 10 дугаар сарын 23-аас 26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулахаар ажиллаж байна.

Энэ туршлага судлах уулзалт сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын төлөөлөл, Улсын дээд шүүхийн төлөөлөл мөн оролцох юм.

7. Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах, Улс төрийн намын дотоод ардчилалтай, хяналттай, хариуцлагатай, ил тод ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг улс төрийн нам олон нийтэд тайлбарлан таниулах, хуулийг нэг мөр зөв ойлгуулах хэрэгцээ шаардлагад үндэслэн уг хуулийн хэрэглээний гарын авлагыг боловсруулах асуудлаар санхүүжилт хүсэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрт хандсан.

Уг хүсэлтийн дагуу энэ онд багтаан гарын авлага боловсруулах ажил эхлээд байна.

Энэхүү гарын авлага нь цаашид уг хуулийг улс төрийн нам, олон нийтэд тайлбарлан таниулах, үйл ажиллагааны үндсэн хэрэглэгдэхүүн болох бөгөөд хуулийн үндсэн зорилго, үзэл баримтлалын талаар улс төрийн нам, олон нийт үнэн зөв, нэг мөр ойлголттой болж хуулийн хэрэгжилтийг талууд бүрэн хангах боломж бүрдэх юм.

8. Улс төрийн намын тухай хууль Монгол Улсын Их Хурлын сонгуулийн

тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх дээрх сургалтуудыг хуваарийн дагуу 11 дүгээр сард багтаан дуусгах бөгөөд сургалтын үйл ажиллагаа дууссаны дараа 12 дугаар сард батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах талаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бүх улс төрийн намуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Уг уулзалтаар Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл зорилгыг тодорхойлсон бодлогын баримт бичиг буюу намын хөтөлбөрийг Монгол Улсын Үндсэн хууль болон Улс төрийн намын хуульд заасны дагуу боловсруулах, 2024 оны ээлжит сонгуулиас өмнө иргэд, сонгогчидтой нээлттэй танилцах боломжийг бүрдүүлэх асуудлаар зөвлөмж өгөхөөр төлөвлөж байна.

Хоёр.Хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

1.Сонгуулийн хууль тогтоомж болон Улс төрийн намын тухай хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах зорилгоор 2023 оны Сонгуулийн ерөнхий хорооны А39 дүгээр захирамжаар 5 сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна.

Дээрх батлагдсан хөтөлбөрийн дагуу бүх шатын сонгуулийн хороодод ажиллах төрийн албан хаагчдад улс төрийн нам, түүний гишүүд, дэмжигч иргэд, сонгогчдод дээрх хоёр хуулийг

тайлбарлан таниулах, мэдээлэл өгөх сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хуваарийн дагуу зохион байгуулж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр “Бодлогот залуус” төрийн бус байгууллагуудтай хамтран 2023 оны 8 дугаар сарын 25-аас 29-ний хооронд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад, 2023 оны 9 дүгээр сарын 17-оос 22-ны өдөр Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгуудад, Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран 2023 оны 9 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад, 2023 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Дархан-Уул аймагт, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймгуудад, 10 дугаар сарын 06-ны өдөр Төв аймагт зохион байгуулсан бөгөөд 2023 оны 10 дугаар сард нийслэлийн 9 дүүрэг болон бусад аймагт мэдээлэл өгөх уулзалт, сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, ярилцлага, хөтөлбөрт оролцох чиглэлээр Монголын Үндэсний Радиотой хамтран сонгуулийн боловсролд радиогийн цуврал нэвтрүүлгийг бэлтгэн нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач, сэтгүүлчдийг бэлтгэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд байгуулагдсан Сонгуулийн боловсрол клубээр дамжуулан дээрх хоёр хуулийн талаарх онцлог өөрчлөлт, үзэл баримтлалын талаар сэтгүүлч, судлаачдад

мэдээлэл өгөх уулзалт, сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Сонгуулийн боловсрол олгох, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, судалгааг сонгогчдод хүргэх зорилгоор улирал тутам **“Сонгуулийн боловсрол” сэтгүүлийг** 2003 оны 3 дахь дугаарт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон онцлог зохицуулалтын талаар мэдээлэл бэлтгэн цаасан болон цахим хэлбэрээр сонгогчдод түгээх ажлыг зохион байгуулж байна.

Мөн сонгогчдод сонгуулийн боловсрол олгох зорилгоор **“Сонгогчийн ном” эмхэтгэлийг** хэвлүүлэн сонгогчдод цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлэх, номын сан үүсгэх ажлыг зохион байгуулж байна.

Гурав. Сонгуулийн автоматжуулсан систем, аюулгүй байдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:

2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдлийг нөхөн бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэнээр Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалт, 28.3 дахь хэсэг Сонгуулийн ерөнхий хороо, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан 2019 оны тушаалаар батлагдсан сонгуулийн автоматжуулсан хэрэгслийн иж бүрдлийг нийлүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах

журмын 6.1-д заасны дагуу **“Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс”**-ыг байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Энэ удаа 507 санал тоолох төхөөрөмж, түүний иж бүрдлийг худалдан авч нөхөн бүрдүүлэлт хийхээр ажиллаж байна.

Сонгуулийн ерөнхий хороон дээрх Мэдээлэл, технологийн төвийн сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдэл, саналын хуудасны загвар бэлтгэх, санал хураалтын дүнг нэгтгэх программ хангамжууд, техникийн үзлэг хийх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна.

Энэ үзлэгээр 2493 санал тоолох төхөөрөмж, 2150 хяналтын камер, 10 сервер, тэдгээрийг дагалдах хэрэгслийг нэг бүрчлэн шалгаж, сонгуульд ашиглах бэлтгэлийг хангасан.

Дөрөв. Хүний нөөцийг бүрдүүлэх чадавхжуулах ажлын хүрээнд:

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Уг хуулийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан бөгөөд үүнтэй холбоотойгоор уг чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийн нэгж байгуулах, Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурлын тогтоолоор тогтоолгох асуудлаар санал, дүгнэлтээ бэлтгэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн.

Мөн Төрийн албаны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу шинээр нэмэгдэх орон тоо бүрээр албан тушаалын тодорхойлолтыг гаргаж, батлуулах ажлыг зохион байгуулж байна.

Шинээр бүрдүүлэх дээрх бүтэц, нэгж, орон тоотой холбоотойгоор шаардлагатай төсвийг 2024 оны төсвийг хийж Сангийн яаманд хүргүүлсэн боловч дээрх орон тоогоор нэмэгдэх бүтэцтэй холбоотой зардлууд одоогийн байдлаар төсвийн хяналтаар хасагдаад байгаа.

Та бүхэнд анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: П.Дэлгэрнарэн даргад баярлалаа.

Байнгын хорооны зүгээс Сонгуулийн ерөнхий хороонд санал тавиад Сонгуулийн тухай хууль батлагдсан, Улс төрийн намын тухай хууль батлагдсан.

Үүнтэй холбоотой дүрэм, журмууд гарах ёстой. Бэлтгэл ажил нь хэр хийгдэж байна.

Хойтон явагдах сонгуулийн, ялангуяа техник, технологийн хангамжийн талаарх асуудал.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдоод Сонгуулийн ерөнхий хорооны бүтэц, зохион байгуулалт орж

байгаа өөрчлөлтийн талаар жишээ нь Байнгын хорооны зүгээс, Улсын Их Хурлын зүгээс ямар арга хэмжээ авах шаардлагатай байгааг танилцуулна уу гэсэн ийм хүсэлт тавьсны дагуу өнөөдрийн мэдээллийг хийж байгаа.

Сая нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ.

Одоо П.Дэлгэрнарэн даргын танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрээ өгье. Асуулттай хүн байна уу?

Ц.Мөнхцэцэг гишүүн. Дараа нь М.Оюунчимэг гишүүн. Тэгээд би сүүлд нэг асуулт асууна. Баярлалаа.

Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр 2024 оны Улсын Их Хурлын сонгууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, мөн Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хуулийн шинэ томоохон эрх зүйн зохицуулалтын дагуу хийгдэх хариуцлагатай сонгууль байгаа.

Ялангуяа Улс төрийн намын тухай шинэ хуулиар улс төрийн намууд бодлогын өрсөлдөгч буюу бодлогын институт болж, намуудын бодлого, мөрийн хөтөлбөр олон нийтэд ил тод хэлэлцүүлэгддэг, намын дотоод санхүүжилт маань байнга тайлан тавьж, хариуцлагатай нээлттэй болох ийм чухал зохицуулалт орж байгаа.

Үүнийг дагаад Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн статус өргөжиж, улс төрийн намын санхүүжилт, намын үйл ажиллагаанд хяналт тавих, улс төрийн намыг бодлогын нам болгон төлөвшүүлэх үйл хэрэгт төрийн гол

институт болж байгаа учраас бид энэ асуудлыг их анхаарч байна.

Тэгээд ер нь өнгөрсөн жилүүдийн сонгуулийн дүн, сонгуулийн ирцийг харахад залуучуудын маань сонгуулийн идэвх их доогуур байгаа.

Ер нь энэ олон улсын чиг хандлага ийм байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр залуучуудын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх, сонгууль хариуцлагатай иргэний төрдөө оролцох гол механизм гэдгээрээ иргэдийн сонгуулийн идэвхийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд эхэлсэн явж байгаа юм байна.

Тэр тайлангийн 2.3 дээр сонгуулийн боловсролтой холбоотой радиогийн цуврал нэвтрүүлэг бэлдэж байгаа гэсэн байна.

Тэгэхээр залуучуудын мэдээлэл авах гол суваг бол нийгмийн сүлжээ. Нийгмийн сүлжээний нэлээд олон шинэ аппликэйшн форумууд байгаа.

Тэгэхээр энэ тал руу анхаарсан ажлууд ер нь хийгдэж байгаа юу?

Ер нь залуучуудын ирц ирэх сонгууль ямар байх вэ? Энэ талаар эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хэр хамтарч байна вэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь, Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намыг бодлогын институци болгон төлөвшүүлэх, намын санхүүжилтийг ил тод болгох тал дээр хүний нөөц болон бусад техник, технологийн томоохон өргөжүүлэх шаардлага байгаа.

Гэтэл үүнтэй холбоотой бүтцийн нэгж, орон тоотой холбоотойгоор төсөвт өгсөн санал дээр энэ санхүүгийн тооцоо, төсөв хянагдаж буюу Сангийн яам хассан байна гэж байна.

Энэ чухам хэдэн төгрөгийн төсөв хасагдчихав.

Ер нь Сонгуулийн ерөнхий хорооны шинэ бүтэц, энэ ачаалал 2024 оны шинэ сонгуультай холбоотойгоор бүтцийг бид нэмэх шаардлагатай. Тэр дундаа олон нийт рүү чиглэсэн, иргэд, сонгогчдын боловсрол руу чиглэсэн ажлуудыг хийхэд одоо байгаа Сонгуулийн ерөнхий хорооны бүтэц, хүний нөөцийг нэмэх шаардлагатай байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр төсвийг хасаж танамааргүй байна.

Тэгэхээр Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэх үед Та бүхэн энэ саналаа бидэнд илүү тодорхой тавимаар.

Яг хэдэн төгрөгийн санхүүжилтийн төсөв хасагдчихав. Үүнээс болоод сонгууль зохион байгуулахад ямар бэрхшээл гарах вэ гэдгийг асуумаар байна.

Н.Энхболд: П.Дэлгэрнараран дарга. 3 дугаар микрофон.

П.Дэлгэрнараран: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Бид саяын танилцуулга дээр шинээр нэмэгдэж хийсэн нийгмийн тодорхой бүлгүүд рүү хандаж, мэдээлэл түгээх, тэдэнд ойлголт өгөх ийм явуулж байсан ажлуудаасаа дурдсан.

Түүнээс гишүүний хэлж байгаа одоо тэр цахим орчныг ашиглах, шинээр дэлгэрч байгаа хамгийн их үр дүнтэй сурталчилгааны хэлбэрүүдийг бид бүгдийг нь ашиглана.

Энэ хоёр төрлөөр явагдана. Нэг нь, сонгуулийн байгууллагаас хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр бүх төрлийн ажлуудыг хийнэ.

Ер нь он гараад энэ сурталчилгааны хэлбэр улам эрчимжинэ.

Нөгөөх нь, нэр дэвшигчдийн сурталчилгаатай холбоотой асуудлыг бас тусгай журмаар Харилцаа, холбооны зохицуулах хороо, Сонгуулийн ерөнхий хорооны хамтарч батлах, хэрэгжүүлэх ийм юм байгаа. Энэ дээрээ ч гэсэн бид сурталчилгааны үр дүнтэй хэлбэрүүдийг тооцож ажиллана.

Хоёр дахь асуудал дээр, бид одоогийн байдлаар манай Сонгуулийн ерөнхий хорооны хуучин ажлын алба байсныг Улс төрийн намын хууль батлагдсантай холбоотойгоор энэ хуулийг дагаж орсон Төв байгууллагын тухай хууль дээр энэ ажлын албыг Тамгын газар болгож өргөжүүлсэн.

Тэгээд энэ Тамгын газар дотроо Улс төрийн намын тухай хуулиар манай сонгуулийн төв байгууллага ямар чиг үүрэгтэй байхыг бас энэ дагаж орсон Төв байгууллагын хууль дээр 10 төрлийн одоо бүр тодорхой заагаад өгчихсөн байгаа.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай бүтэц болон хүний нөөцийг шинээр бий болгож, томилж ажиллуулах ёстой.

Тэгэхээр энэ дээр бид Тамгын газрынхаа орон тооны дээд хязгаарыг Улсын Их Хурлаар батлуулах ёстой. Үүнийхээ төлөвлөлтийг бид хийчихсэн. Байнгын хороонд хүргүүлчихсэн.

Сая бид нарын хуучин ажлын алба ажиллаж байсан хэсгийг хэвээр нь Сангийн яам хянаад үлдээсэн байгаа.

Шинээр төлөвлөсөн Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой энэ бүтэц, орон тооны маань санхүүжилт цалин, нийгмийн даатгалын сантай холбоотой юуг хасчихсан байгаа.

Тэгээд энэ бол 2.1 тэрбум төгрөг байгаа юм. 2 тэрбум 147 сая төгрөгийн төсөв байгаа. Баярлалаа.

Н.Энхболд: Болсон уу? Нэмэлт 1 минут. Ц.Мөнхцэцэг гишүүнд.

Тэгэхээр мэдээж цар тахлын хямрал болон бусад нөхцөл байдлын улмаас улс орны төсөв угаасаа хязгаарлагдмал байгаа.

Бид санхүүжилт хийх гол зүйлүүдийг эрэмбэлж, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, ардчиллын бэхжилт, иргэдийн улс төрийн оролцоо дэмжих чиглэлд анхаарах.

Хүний эрхийг ханган сайжруулах чиглэлийн төсвүүдийг танах ёсгүй.

Гэтэл сонгуулийн ерөнхий байгууллага маань Монголын ардчиллын гол институт болж байгаа улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгох, намууд бодлого даргын нам болж, улс орны хөгжлийн бодлогын төлөө өрсөлдөх энэ институт болох чиглэлд шинээр эрх

зүйн нэлээд олон үүрэг, функц хүлээж байгаа.

Үүнийг хэрэгжүүлэн ажиллах гол бүтцийн нэгжийн орон тоог, түүний төсөв болон хүний нөөцийг хэрэгжүүлэх энэ механизмыг дэмжих ёстой.

Тийм учраас Сангийн яам болон манай гишүүдтэй энэ Сонгуулийн ерөнхий хорооны төсвийг яг.../минут дуусав/

Н.Энхболд: Санал нэг байгаа шүү. Би дараа нь үг хэлнэ. М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Санхүүжилт, хүний нөөцтэй холбоотой асуудал үнэхээр чухал асуудал. Энэ дээр Та бүхэн маань онцгой анхаарч байгаа байх. Бид ч гэсэн дэмжихэд бэлэн байна.

Хамгийн гол нь үүний гол зорилго нь юу юм гэхээр бид энэ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын гол зорилго нь парламентын ардчилал, чадавхыг сайжруулах, иргэдийн сонгох эрхийг шударгаар хангах асуудал өөрөө хамгийн чухал байгаа. Одоо энэ дээр сонгуулийн үед янз янзын юм гардаг шүү дээ.

Сонгуулийн хороодод тухайн хүмүүс, намын дарга нар, тухайн дүүргийн юм уу, аймаг, сумын намын дарга нар өөрсдийнхөө хүмүүсийг оруулах, тэнд шударга бус юм оруулах гэх мэт тийм зөрчлүүд өмнө нь маш их гардаг. Тийм ээ.

Тэгэхээр Та бүхэн маань яг энэ хүний нөөц, ялангуяа шударгаар сонгох эрхийг хангах чиглэл дээр ингэж бид бэлтгэл ажлыг хангаж байгаа гэсэн дээр

та нэг товч мэдээлэл өгөөч. Энэ их чухал байгаа.

Хоёр дахь асуудал нь, сонгуулийн нөгөө автоматжуулсан системийн аюулгүй байдал, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах чиглэлээр энд шалгарах компанийг тендерийг нь шалгаруулах ажил явагдаж байна гэж байна. Тийм ээ.

Тэгэхээр Та бүхэн маань энэ дээр жишээ нь хаанаас ямар тоног төхөөрөмж авах тухай. Өмнө нь бас энэ тоног төхөөрөмжийг дагаад хардлагууд их яваад байсан шүү дээ? Программыг нь дээрээс уншдаг. Эвэл манай улс өөрөө үүнийгээ удирдаж чадаж байна уу, үгүй юу ч гэдэг юм уу. Нөгөө “хар машин” гээд бид нэрлээд дадчихсан. Үүнийг дагасан хардлагууд байдаг.

Гэхдээ яг үнэндээ сонгуулийн дүн гарахад энэ машин маань маш шударгаар гардгийг би өөрөө мэдэрсэн л дээ. Тэгэхдээ бид одоо энэ шинээр суурилуулах гэж байгаа 507 санал тоолох төхөөрөмж маань хаанаас яаж авах вэ?

Үнэхээр чанарын баталгаа хангасан шударга, тэр сонгогчдын эрхийг хамгаалаад гаргаад ирэх тал дээр Та бүхэн маань тендерээ зарлахдаа, сонгон шалгаруулалт хийхдээ, тоног төхөөрөмжөө авахдаа хэр анхаарч бэлтгэл хангаж байгаа вэ гэдэг дээр асуулт байна аа? Баярлалаа.

Н.Энхболд: П.Дэлгэрнаран дарга.

П.Дэлгэрнаран: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулья.

М.Оюунчимэг гишүүн их чухал сэдвийг биднээс асууж байна гэж бодож байна.

Ингээд энэ бүх шатны сонгуулийн байгууллагад ажиллах улсуудыг хуулиар төрийн албан хаагчид гүйцэтгэхээр хуульчилж заасан. Төрийн жинхэнэ албан хаагчид юм уу, эсвэл төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтнууд байхаар. Төрийн үйлчилгээний албан тушаалтнууд ажиллахаар заасан.

Тэгэхээр одоо бид өнгөрсөн хугацаанд ээлжит сонгуулиуд дээр 10 гаруй мянган хүн дайчлагдаж ажилладаг. Өөрөөр хэлбэл сонгон шалгаруулагдаж.

Энэ улсууддаа бид сургалт зохион байгуулаад сертификат олгож сонгуулийн байгууллагад ажиллуулдаг.

Бид энэ сонгуулийн хууль тогтоомж өөрчлөгдөх болгонд, ээлжит сонгуулиуд явах болгонд шинэчилсэн байдлаар хүмүүсээ бүртгэж, одоо энэ бүртгэлийн ажиллагаа харьцангуй боловсронгуй болж цахим болсон.

Тэгээд өөрсдийнх нь хүсэлтийг аваад, ингээд эд нарыгаа нэгдсэн сан үүсгээд бүртгээд, энэ улсуудыгаа сертификатжуулаад сургалтыг цаг тухайд нь хийж явуулдаг ийм ажилтай.

Тэгэхээр төрийн албан хаагчид маань сүүлийн үед харьцангуй их чадавх сайжирсан. Энд хоёр, гурван сонгууль дамжиж ажиллаж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа. Харьцангуй туршлагатай болж байгаа.

Шинээр сонгуульд ажиллаж эхэлж байгаа хүмүүсийгээ дадлагажуулах, сургах асуудал дээр бид онцгой анхаарч байгаа.

Төрийн албан хаагчдаас ажиллах хүмүүсийнхээ нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлээд бид тэднийгээ системтэй бүсчлээд. Гол нь энэ дээр сургалтаа чанартай зохион байгуулах, дадлага мэдлэг олгох энэ л ажил чухал байгаа юм. Тийм.

Хууль тогтоомжийн хувьд бас нэг орсон өөрчлөлт гэвэл хуучин сонгуулийн шат шатны хороодыг даргалж байсан хүн нь зүгээр төрийн албан хаагч гэсэн учраас ямар ч хамаагүй төрийн албан хаагчийг томилдог байсныг одоо бүх шатын Засаг даргын Тамгын газрын дарга нь ахалдаг болохоор илүү их хариуцлагатай болгож хууль тогтоомж өөрчлөгдсөн байгаа.

Хоёр дахь асуудал нь, энэ сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг бид сая төсвийн тодотголоор шийдсэн.

Тэгээд бид төлөвлөсөн цаг хугацааныхаа дагуу график хоцролгүйгээр ажлууд маань зохион байгуулагдаад явж байгаа.

Би сая дурдсан. Сангийн яам, Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хамтарсан гурван байгууллагын журам байдаг.

Энэ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа. 2019 оны. Энэ журмын дагуу бид шууд худалдан авалтыг зохион байгуулж байгаа.

Энэ төхөөрөмж угаасаа худалдан авах газар нь нэг л газар байгаа. **“Dominion Voting”**¹ гээд.

¹ 2003 онд байгуулагдсан Dominion Voting Systems нь АНУ, Канад болон дэлхийн хэмжээнд сонгуулийн технологийн ханган нийлүүлэгч.

Одоо тэгээд тэр газраасаа бид 507 төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт нөхөн бүрдүүлж хийж байгаа.

Одоо өнөөдрийн байдлаар бид нарт 2493 төхөөрөмж яг бэлэн ажиллагаатай, ашиглалтын шаардлага хангасан байдалтай байгаа.

Н.Энхболд: М.Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Энэ шударга явах гэдэг дээр яг энэ тоног төхөөрөмжийн асуудал маш чухал.

Та бүхэн маань 200 гаруйг нь шууд худалдан авалтаар аваад байна гэж байна. Энэ шинэ тоног төхөөрөмж үү? Энэ дээр ажиллах нөгөө ИТ-гийн ажилтнууд байгаа шүү дээ. Мэдээллийн технологийн ажилтнууд энэ тэрээ яаж сонгох вэ, сонгож байгаа вэ? Энэ асуудал чухал. Шинэ үү, үгүй юу? Тийм ээ. Хуучин нэг л газраасаа авч байна гээд та нар сая хэллээ.

Н.Энхболд: 3 дугаар микрофон. П.Дэлгэрнарэн дарга.

П.Дэлгэрнарэн: Тоног төхөөрөмж маань одоогийн байдлаар “**Dominion Voting**” компанид үйлдвэрлэсэн “**Ай Си Пи - 1**” /Image Cast Precinct (ICP)/ гэдэг төхөөрөмж одоо манайд байгаа, ашиглагдаж байгаа.

Энэ төхөөрөмж маань 10 гаруй жилийн өмнө бид авч анх эхэлж ашигласан төхөөрөмж.

Үүнээс хойш уг төхөөрөмж маань боловсронгуй болоод “**Ай Си Пи - 2**” гэдэг төхөөрөмж гарсан.

Одоо ирж байгаа 507 төхөөрөмж маань “Ай Си Пи – 2” энэ хоёр төхөөрөмж маань харилцан бие биеийгээ таньж унших, нэг сүлжээнд ажиллахад техникийн хувьд ямар ч асуудалгүй. Энэ “Ай Си Пи – 2” гэдэг бүгдээрээ шинэ төхөөрөмжүүд ирж байгаа. Тийм.

“Ай Си Пи – 1”-тэйгээ 1 сүлжээнд ажиллахад ямар ч асуудалгүй. Харилцан юу гарахгүй.

Н.Энхболд: 3 номерын микрофон өгье. Нэмж хариулна.

П.Дэлгэрнарэн: Мэдээлэл технологийн даамлууд гээд яг одоо энэ цахим тоног төхөөрөмжүүдийг ажиллуулдаг, яг манай сонгуулийн бүх шатын хороонд ажилладаг шиг яг энэ мэдээллийн технологийн даамлууд ажилладаг.

Энэ маань бас манайд нэгдсэн бүртгэлтэй, бас сертификатжуулдаг.

Тэгээд эд нарынхаа нөөцийг дунд нь зохион байгуулалтад оруулаад энэ төхөөрөмжөө ажиллуулах хүмүүсээ бид сургалтаар бэлддэг.

Энэ сургалтаар бэлдэх хүмүүсийн маань нөөц бүртгэл манай дээр хангалттай байгаа.

Яг одоо манай дээр байгаа Мэдээлэл, технологийн төвийн орон тоогоор ажиллаж байгаа хүмүүсийн хүний нөөцийн бүрдүүлэлт одоогоор боломжтой байгаа.

Бид 11 сард энэ төхөөрөмжийг худалдаж авсан газар дээрээ Америкийн Нэгдсэн Улсад очиж газар дээр нь сургалт хийнэ. Яг программ хангамжтай холбоотой мэргэжилтнүүдээ.

Тэднийхээс тоног төхөөрөмжийг нийлүүлээд дуусахаараа он гараад манай дээр ирж сургалтаа бас хийхээр ийм ажил явж байгаа.

Н.Энхболд: Ганцхан товч асуулт байна.

Саналын хуудасны загвар бэлдээд, янз бүрээр машинтайгаа уялдуулах болж байна уу, үгүй юу, туршилтууд явж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр асуулт юу вэ гэхээр шинэ хуулийн дагуу холимог тогтолцоогоор явдаг болсон. Намуудын идэвх сэргэж байна. Сонгуульд урьд өмнөхөөс илүү олон нам, илүү олон нэр дэвшигч орох ийм магадлал байгаа.

Тэгэхээр энэ бүхнийг одоо бидэнд байгаа тоног төхөөрөмж, уншдаг төхөөрөмж маань ямар нэгэн бэрхшээлгүйгээр уншаад байх тийм боломж байгаа юу?

Өөрөөр хэлбэл санал хураах хуудасны загваруудаа туршиж үзэж байгаа энэ явцаас чинь харахад энэ дээр ямар нэгэн бэрхшээл, түвэг гарахгүй биз гэсэн ийм асуулт байна.

Яах вэ нийгмийн дунд бас ойлголт байна л даа. Олон хүн орохоор их олон нэр жагсаана. Тэрийг нь бүгдийг нь уншиж чадах юм уу, үгүй юу. Гучин хэдэн нам орно. Бүгдийг нь уншиж чадах юм уу, үгүй юу гээд л.

Тэгэхээр энэ эргэлзээг тайлахын тулд яг загвар дээр машинтайгаа ажиллаад ямар нэгэн асуудалгүйгээр сонгуулиа явуулчих ийм бололцоо байгаа юу гэдэг тал дээр товчхон хариулчихъя.

3 дугаар микрофон. Дараа нь Д.Бат-Эрдэнэ дарга шаардлагатай нэмж болно шүү.

П.Дэлгэрнарэн: Саналын хуудастай холбоотой асуудлыг бид хуульд заасны дагуу хувилбаруудаар хийж үзэж байна, туршиж байна.

Ер нь саналын хуудасны загварыг Сонгуулийн ерөнхий хороо баталдаг.

Ингээд сонгуулийн ажил эхлэхээр. Үүнээсээ өмнө бид техникийн хувьд ямар байх нь вэ, сонгуулийн саналын хуудас маань ямархуу байж болох вэ, техник хэрэгсэл маань хэр зэрэг үүнийг амжилттай уншиж байна гэдэг туршилтуудыг бид хийж байгаа.

Саналын хуудсаа ар өвөргүй хийж үзэж байна. Хоёр талаар нь хийж үзэж байна. Нэг талаар нь хийж үзэж байна.

Одоогийн саналын хуудас 2012 оны саналын хуудастай төстэй болно. 2012 онд мөн сонгуулийн систем маань ийм систем байсан.

Тэгэхээр ийм төстэй байсан. Тэгээд бид олон төрлөөр хийж үзээд төхөөрөмждөө уншуулж туршиж үзсэн. Энэ бол бүрэн боломжтой байгаа.

Н.Энхболд: Баярлалаа. Л.Лхамжав дарга энэ дээр нэмэх юм байна уу?

Яг Мэдээллийн технологийн төвийнхөө захирлын үүргийг гүйцэтгэж

байгаа хүний хувьд. Даргатай санал нэг байгаа юу? Бүрэн боломжтой. Асуудал гарахгүй ээ гэдэг дээр. Микрофондоо хэлчих. 6 номерын микрофон.

Л.Лхамжав: Н.Энхболд даргын асуултад хариулъя.

Даргатай санал нэг байна. Саналын хуудасны загварыг бид төрөл бүрийн хэлбэр форматаар хийж уншуулж үзэж байгаа. Энд ямар нэгэн хүндрэлтэй асуудал гарахгүй.

Н.Энхболд: Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо танилцуулгатай холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Сонгуулийн ерөнхий хорооныхондоо баярлалаа.

Сонгуулийнхаа бэлтгэл ажлыг графикайн дагуу явуулж байгаа гэж ойлгож байгаа. Тийм ээ.

Тухай тухайн үед нь ямар нэгэн асуудлаар холбогдох Байнгын хороондоо манайд хандаад ийм зүйлүүд байна. Үүнийг эрх зүйн талаас нь зохицуулах юмнууд гарвал даруй даруйд нь хэлээд явж байгаарай.

Төсөв мөнгөтэй холбоотой асуудлыг сая манай гишүүд ч хэлж байна.

Бүтэц, зохион байгуулалт, орон тоотой. Энэ талаар бид хуульчдынхаа зүгээс энэ төсвийг хэлэлцэх үеэр саналаа оруулж ярина.

Их Хурлын удирдлага, Сангийн яамтай ярих нь зүйтэй гэж бодож байгаа.

Яагаад гэвэл нэгэнт шинэ хууль гарсан бол бид тэрийг хэрэгжүүлэх тал дээр нь л ажиллах ёстой.

Тэр тусмаа төрийн эрх барих дээд байгууллага сонгох сонгуулийн ажлыг ямар нэгэн. Эрх биш Монгол Улс түүндээ тодорхой хэмжээний хөрөнгө гаргаад сонгуулиа ямар нэгэн будилаангүйгээр явуулах бололцоо байгаа гэж харж байна.

Энэ чиглэлээр хамтраад ажиллах шаардлагууд байгаа гэдгийг хэлье.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хороогоор Сонгуулийн ерөнхий хорооны сонгуульд бэлтгэх ажлын явцын талаарх танилцуулгыг сонсож дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооноор хэлэлцэх асуудлууд дууслаа.

Оролцсон гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 48 минут үргэлжилж, 15 цаг 06 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД